Эдийн засаг, Нийгмийн хөгжүүлэлт



Монгол Улсын зүгээс байгалийн хийн хоолойн төслийг онцгойлон анхааралдаа байлгаж, төслийн хэрэгжилтэд бодлогын дэмжлэг үзүүлэн ажиллаж байна. Тухайлбал, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 тоот тогтоолоор баталсан *“Алсын хараа-2050”* Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт “Бүс нутгийн эдийн засаг, худалдааны интеграцид нэгдэж, худалдааг хөнгөвчлөх зорилтын хүрээнд Эдийн засгийн коридорын “Талын зам” хөтөлбөрийг хэрэгжүүлж, Монгол Улсын газар нутаг дээгүүр дамжин өнгөрөх байгалийн хийн хоолойг барих асуудлыг гурван талт хэлэлцээрийн үр дүнд шийднэ” гэж тусгасан.



Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор баталсан “*Шинэ сэргэлтийн бодлогын баримт бичиг”*-т ОХУ-аас БНХАУ руу Монгол Улсын газар нутгаар дамжин өнгөрөх байгалийн хий дамжуулах хоолойг барих бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлнэ” гэж заасан.

Мөн Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 тоот тогтоолоор баталсан *Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт* “Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжуулан ОХУ-аас БНХАУ руу баригдах байгалийн хий дамжуулах хоолойн ТЭЗҮ-ийг дуусгаж, барилга угсралтын ажлыг эхлүүлэх бэлтгэл хангана” гэж тусгасан нь энэхүү төсөл урт болон дунд хугацааны бодлогын нэгдсэн чиглэлийн хүрээнд бүрэн дэмжлэг хүлээж байна.